

УЛСЫН ШАЛГАЛТ - 2023

МОНГОЛ ХЭЛ

V АНГИ

Аймаг/дүүрэг:

Сум:

Сургууль:

Анги: Бүлэг:

Овог:

Нэр:

САНАМЖ, ЗӨВЛӨГӨӨ

- Эхийг анхааралтай уншаад, даалгавруудыг гүйцэтгээрэй.
- Шалгалт 60 минутад үргэлжлэх тул цагаа сайтар төлөвлөж, зөв хуваарилан, бүх даалгаврыг гүйцэтгээрэй.

Төрсөн өдрийн бэлэг

Аав нь Одхүүгийн төрсөн өдрөөр гар чийдэн бэлэглэлээ. Мөнгөлөг цагаан гэртэй. Асааж унтраах улаан ногоон товчлууртай. Одхүү бэлгээ тэврэн дэвхцээд бөөн баяр. Тэр дороо л авдрын ар, орны хөндийгөөр гэрэлтүүлэн хол ойрын тусгалыг нь шалгаж эхэллээ. Аав нь бүрэнхий байгаа тул хашаанаас гарч болохгүйг сануулан хэлэв. Хаврын намуухан үдэш алгуурхан айлчилж одод түгж, бүлээхэн салхи сэвэлзэнэ. Одхүү гар чийдэнгээ мэлс мэлсхийтэл асааж, бүхнийг гэрэлтүүлж эрхэлнэ. Сагсгар жаахан гөлөг нь гар чийдэнгийн гэрэлд үе үе орж, илбэдүүлсэн мэт болж гайхна. Гэтэл түүний сайн найз Дорлиг дуудав. Тэд уулзаад нуугдаж тоглолоо. Тэгээд удалгүй уйдаж хашаанаасаа гарч, үлгэрийн мэт адал явдал хайхаар шийдэв. Хажуу айлаасаа том гэгчийн шүүрэн шанага барьсаар гарч ирсэн 5а ангийн сурагч Туяа байлаа. Хөвгүүд Туяагийн нүүрэн дээр гэрэл анивчуулан -Онц сурлагатан Туяад оройн мэнд хүргэе гэж зэрэг шахам мэхийн ёсоллоо. Туяа - Би яарч явна гэхэд Дорлиг: Одхүүгээс гар чийдэнг нь булаан авч, Туяагийн бараг хамрыг нь шүргэх шахам тулгав. Туяа тэгтэл, Ээж ээ! гээд байдаг чадлаараа хашхирах нь тэр. Хөвгүүд ч гудамжны үзүүр тойрон зугтаж амжлаа. Одоо чиний гар чийдэнгийн холын тусгалыг шалгаж үзье. Автобусны буудал руу явъя гэхэд Одхүүд сонирхолтой санагдаад үгүй гэсэнгүй ёстой догь санаа байна шүү гээд хүлээн авлаа. Тэднийг буудал хүрэх замд хүмүүс элдэв зарлал нааж заншсан их өндөр төмөр шон тааралдлаа. Одхүү шон өөд гэрэл тусган: . . . Хашаа байшин зарна. . . 101 тоотод мод зарж байна. . . гэх мэтээр чанга дугаар уншина. Дорлиг: -Зай нь муудаж байх шиг байна. Зарим бичиг нь харагдахгүй юм. Хамгийн дээд талд наасан бичиг дээр тусга уншиж чадсангүй. Одхүү: -Намайг өргө, бичиг өөд авиръя. Хүмүүст би самбаатай мундаг харагдана даа гэж хөгжилтэй хэлэв. Одхүү дээш авирсаар бичигт бүр ойртож гар чийдэнгээ мэлсхийтэл асаалаа. Зарлалын үг үсэг ч тодоос тод дурайна. “Энэ шонг өнөөдөр будсан тул хувцсаа будахаас болгоомжил” гэж бичжээ. Одхүү аавынхаа хэлсэн үгийг сонсолгүй хашаанаас гарч явсандаа ихэд гэмшлээ.

1. Одхүүгийн автобусны буудал явах болсон учрыг эхийн эхлэл хэсгээс олж бичээрэй. /2 оноо/

.....

.....

.....

2. А. Эхийн үйл явдал ямар улиралд болж байна вэ? /1 оноо/

.....

- Б. Хариултаа батлах жишээ өгүүлбэр хоёрыг эхээс олж бичээрэй. /2 оноо/

.....

.....

.....

.....

3. А. Дорлигийн хийсэн үйл, хэлсэн үгийг ялган бичээрэй. /2 оноо/

.....

.....

.....

.....

Б. Дорлигийн хийсэн үйл, хэлсэн үгэнд үндэслэн зан чанарыг тодорхойлж бичээрэй. /2 оноо/

.....

.....

.....

.....

4. Хүснэгтэд Одхүүгийн зан чанарын өөрчлөлтийг дүгнэн бичээрэй.

Эхлэл хэсэгт ямар зан чанартай байсан бэ?	Төгсгөл хэсэгт ямар зан чанартай болсон бэ?
<p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>	<p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
<p>Яагаад өөрчлөгдөх болсон бэ?</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>	

5. Эхийн төгсгөл хэсгээс гол санааг илэрхийлэх өгүүлбэрийг олж бичээд, яагаад өгүүлбэрийг сонгосноо өөрийн үгээр тайлбарлаарай. **/3 оноо/**

.....

.....

.....

.....

.....

6. “Надад таалагдсан тоглоом” сэдвээр өөрт тохиолдсон явдлаа 100-120 үгэнд багтаан бичээрэй.

Бичихдээ:

- Эхлэлт хэсэгт – Үйл явдал өрнөсөн орчныг дүрслэхдээ хэзээ, хаанаас, хэнтэй гэх мэт асуултад хариулагдах үгсийг сонгоорой.
- Гол хэсэг – Өөрт тохиолдсон, болсон явдлыг бичихдээ яагаад?, ямар учраас? гэх мэт асуултыг бодож бичнэ үү.
- Төгсгөл хэсэгт – Өөрт тохиолдсон явдлаар дамжуулан бусдад ямар сургамжит санаа өгч болох вэ?

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Handwriting practice lines consisting of 25 horizontal dotted lines.